



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/81

Мандалговь

Дуудлага худалдаа зохион байгуулах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/78 дугаар захирамжийн дагуу зохион байгуулагдаж байгаа дахин дуудлага худалдааг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Сумын Засаг даргын орлогч

Хөтлөгч: Газрын даамал

Тэмдэглэл хөтлөгч: Архив бичиг хэрэг

2. Газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах ажлын журам, зааврыг баримтлан ил тод нээлттэй явуулахыг ажлын хэсгийн дарга /И.Эрдэнэцог/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ